



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/69

Цагаан-Уул сум

**Г Хяналт тавьж, хүлээн авах комисс Г
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх фитнесийн танхим байгуулах ажилд хяналт тавьж, хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ахлагч: М.Оюунчимэг (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Гишүүн: Д.Баасанжав (Гал түймэр унтраах аврах 73 дугаар ангийн нярав)

Нарийн бичгийн дарга: Ц.Батгэрэл (Гал түймэр унтраах аврах 73 дугаар ангийн салаан захирагч)

2. Ажлын даалгавар, зураг төсвийн дагуу явцын хяналтыг чанартай зохион байгуулж хянаж, хүлээн авч ажиллахыг хяналт тавьж хүлээн авах комисс (М.Оюунчимэг)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-т даалгасугай

ДАРГА  С.ГОНЧИГНЯМ